

Сэдэв. Багшийг хөгжүүлэх хүчин зүйл нь- Төсөлт ажил хичээлийн бэлтгэл судалгаа

Илтгэгч. Л.Намуунтуяа “Төсөлт
ажил” хичээлийн мэргэжлийн баг

2013.06.14

Сэдэв сонгосон үндэслэл

- Төсөлт ажил хичээлийн бэлтгэл судалгааг хийх явцад багш төсөлт ажлын тулгуур ойлголт болох сэдэв сонгох, төлөвлөлт, судалгаа боловсруулан нэгтгэх, тайлан бичих, үнэлгээ хийх гэсэн 5 зүйлийг мэдэхийн зэрэгцээ тухайн судалж буй сэдвийн задаргаа бүрээр задалсан асуудлыг мөн хичээлийн бэлтгэл судалгаа/агуулга, мэдлэг эзэмшилт, арга зүй, орчин хэрэглэгдэхүүн, үнэлгээ/ 5 алхмыг хөгжүүлэн сайжруулах боломжтой.
- Төсөлт ажил хичээл заадаг багш, зүрх сэтгэлээсээ түүнийг заахаар шимтэн бэлтгэл судалгаагаа сайн хийвэл бусад судлагдахууныг зааж буй багшаас 1 алхмын өмнө хөгжин урагшилдагийг багш нарт ухааруулахыг зорин энэхүү сэдвийг сонгосон.

Хангайн бүсийн төсөлт ажил хичээл заах багш нарыг бэлтгэх сургалтын зорилго

- Төсөлт ажил хичээх заах багш нар 5-р ангийн суралцагч болж нэг сэдвийг сонгон Төсөлт ажил хичээлийн тулгуур ойлголтуудаар мэдлэг бүтээн, төсөлт ажлын мөн чанарыг ойлгон мэдрэх,
- Багшийн байр сууринаас хичээлд ажиглалт хийх явцдаа хичээлийн судалгаанд оролцон арга зүйгээ боловсруулах

Товч утга

- “Төсөлт ажил” хичээлийн бэлтгэл судалгаа хийх явцад багшийн заах арга зүй, судлагдахууны талаарх ойлголтод байнга ахиц гарч багш өөрөө ажлын байрандаа хөгжих боломжийг бүрдүүлдэг.
- Гэвч төсөлт ажил хичээл зааж буй зарим багш нар хичээлийн бэлтгэл судалгаа хийхгүй төсөлт ажил хичээлийг хэлбэр талаас нь ойлгож, мөн чанарыг нь орхигдуулдаг тал бий. Иймд төсөлт ажил хичээлийн бэлтгэл судалгааг сайн хийвэл багш хөгждөг болохыг жишээ баримтаар нотлохыг зорьсон юм.

Түлхүүр үг:

Хичээлийн бэлтгэл судалгаа

- Агуулгын
- мэдлэг эзэмшилт,
- арга зүй,
- сургалтын орчин, хэрэглэгдэхүүн,
- Үнэлгээний судалгаа

Төсөлт ажил хичээлийн тулгуур ойлголт

- сэдэв сонголт,
- сэдвийн задаргаа,
- судалгаа,
- төлөвлөлт,
- явцын тайлан
- эцсийн тайлан.

Онолын хэсэг:

- Япон багш нарын жүгё кенкю нь үндсэндээ бидний хичээлийн хөтөлбөр боловсруулах ажил бөгөөд түүний тулд заах сэдэв, хүүхдийн бэлтгэл, суурь төсөөлөл, хэрэглэх аргаа сонгох зэрэгтэйгээ холбогдуулан **багш өөрөө хийх судалгаа, эрэл хайгуул** юм. Энэ нь багшийг хөгжүүлэх шилдэг арга болно. [Наранцэцэг. Ц, бэлтгэл судалгаанд түшиглэн туршлагаа Төсөлт ажлын арга зүй ЗөвлөмжII, УБ 2009, 87]

Туршилт судалгаа

- Миний бие 2012 онд Хангайн бүсийн “Төсөлт ажил” хичээлийн сургагч багшийг бэлтгэх сургалтын бэлтгэл судалгаанд тулгуурлан тайлбарлая. Хичээлийн зорилгоо дараах байдлаар тодорхойлсон.

Хичээлийн зорилго

- Төсөлт ажил хичээх заах багш нар 5-р ангийн суралцагч болж мэдлэг бүтээн, төсөлт ажлын мөн чанарыг ойлгох,
- Багшийн байр сууринаас хичээлд ажиглалт хийх явцдаа хичээлийн судалгаанд оролцон арга зүйгээ боловсруулах

Туршилт хичээл

- Миний өмнө тулгамдсан асуудал
- 5-р ангийн сурагчдад төсөлт ажлын мөн чанарыг ойлгуулах арга зүйг боловсруулах
- Багш нарт төсөлт ажил хичээл, түүний бэлтгэл судалгааг цогцоор нь өөрөө бэлтгэж үзүүлэх,
- Хичээлээ заан Төсөлт ажил хичээлийн “Хичээлийн судалгааг” ойлгуулах
- Нэг судлагдахуун сонгон түүний дагуу төсөлт ажил хичээлийн мэдлэг бүтээх

Тулгамдсан асуудлаа шийдвэрлэсэн минь

- 5-р ангийн сурагчдын хувьд
- нас сэтгэхүйн онцлог,
- өнөөгийн сурагчдын тоглох дуртай тоглоом,
- Тэдний насны хүүхдүүдээс үлгэр дуурайл болох монголын болон дэлхийн хүүхдүүдийн талаар мэдээлэл,
- сурах үйлийг нь судлах баруун, зүүн тархины хөгжлийн судалгаа
- Цэцэг хялбар хайчлах аргачлал, цаас нугалан цэцэг хийх аргачлалыг олж хичээлийн явцад мэдлэг бүтээхэд хэрэглэсэн.

Хичээлийн бэлтгэл судалгааг шийдвэрлсэн нь

Агуулгын судалгаа:

- Багш агуулга бүрийг судлан 3 өдрийн хичээл заах агуулгыг өөрийн болгон РР мэдээлэл бэлтгэн минут цаг бүрийг төлөвлөсөн.
- Суралцагчид тухайн агуулгыг мэдэж буй талаар судалгаа авсан.
- Судалгаанд үндэслэн агуулгад зохицуулалт хийж хичээл заасан.

Мэдлэг эзэмшилтийн судалгаа:

- орц, явц гарцад хийсэн.

Суралцагчдын мэдлэг эзэмшилтийг дараах 3 байдлаар судалсан.

1. Төсөлт ажил хичээлийн талаар өмнөх төсөөллийг мэдэх зорилгоор орцод \ анхан, дунд, гүнзгий түвшин\, явцад \Хичээл эхлэхэд, Төсөлт ажил хичээл таны ойлголт \
2. Суралцагчийн судалгаа
\Баруун зүүн тархины хөгжлийн , сэтгэлгээний хэв шинж, зан чанар\
3. Сургах үйл ажиллагаатай холбоотой багшийн судалгаа
\10 настай хүүхдийн насны онцлог\, \тоглоомын арга\,
Би чадлаа, гэвч...

Хичээлийн бэлтгэл судалгааны шийдвэрлэлт

- **Арга зүйн судалгаа:**
- Тоглоом,
- дүрд орох,
- өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх,
- бод, хамтар хуваалц,
- оюуны зураглал хийх,
- ханын мэдээлэл,
- үзүүлэн таниулах гэх мэт аргуудыг хичээлийн судлагдахуунд нь тохируулан хэрэглэж, аргачлал бүрийг тодорхой тайлбарлан мэдлэг бүтэлгэсэн.
- **Сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа**
- Материаллаг болон сэтгэл зүй, үйлийн орчинг бүрдүүлсэн.
- Мэдээлэл авах интернетийн орчин
- ярилцлага хийх, уулзалт зохион байгуулах хүмүүсийг тодруулан зохион байгуулсан.


Бэлтгэл судалгааны шийдвэрлэлт

- **Үнэлгээний судалгаа**
- хичээлийн орц, явцад, гарцад мэдлэг эзэмшилтийг үнэлж, орцоос гарцад гарч буй суралцагчдын өөрчлөлтийг үнэлэхийг зорьсон.
- Хичээлийн явцад урамшууллын үг, алга ташилтаар үнэлсэн.

Төсөлт ажил хичээл зааж, Төсөлт ажил хичээлийн хичээлийн судалгааг ойлгуулсан минь

- Алхам 1 Хичээл гэж юу вэ?
- Алхам 2 Хичээлийн судалгааг ямар учраас хийдэг вэ?
- Алхам 3 Хичээлийн судалгааны бүтэц
- Алхам 4 Төсөлт ажил хичээлийн хичээлийн судалгааны онцлог
- Алхам 5 Төсөлт ажил хичээлийн явцын тайлангийн хичээлийг заах
- Алхам 6 Явцын тайлангийн хичээлд ашиглалт хийлгүүлэн хэлэлцүүлэг зохион байгуулах
- Алхам 7 Төсөлт ажил хичээлийн бичлэг үзүүлэн ярилцлага өрнүүлэх

Цэцэг тарих сэдвийг сонгон мэдлэг
бүтээлгэсэн нь ангийн сэдвийн задаргаа



Алтан зул багийн сэдвийн задаргаа



- Цэцэгний орчин
/тасалгааны,
мандлын цэцэг/
- Ач холбогдол
/эрүүл мэнд, энерги,
эрч хүч, ахуй , гоо
сайхан/
- Онцлог
- /ургах, бэлтгэх, яаж
тарих, цэцэглэлтийн
хугацаа/ дэд
сэдвээр судлав.

Бадамлянхуа багийн сэдвийн задаргаа



Цэцгийн төрөл

Тасалгааны

Байгалын

Мандлын

Гоёл чимэглэлийн

Арчилгаа

Бордоо

Усалгаа

Дулаан

Хамгаалах

Орчин

Дараалал

Үр, хөрс, цэцэг, сав
сонгох

Төлөвлөлт

№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Бүх үлсвэр
1	Орчин судалгаа • Төхөлийн • Гадаргуу орчин	15/15.	Гүнзгий	БСГ интерне
2	Ач холбогдол • Ахуйн хэрэгцээ • Эрүүл мэнд • Говь сүйхэн • Энэрг, эрч хүч	15/15.	Цэцэгээ	БСГ. Цахим хэлбэр Биологич бэлдэг
3	Онцлог • Яам тэрэг • Хүчлэг дээдс • Хэрэгсэл • Бэлдэгч	15/15.	Түяа	БСГ. интернет


Алтан Зул Бэг.

Бадмлянхуа Бэг


Төлөвлөлт

№	Нэр	Хийх ажил	Хугацаа	Төлбөр
1.	Хансмаа	БСГ - хулзана.	16 ⁰⁰ - 17 ³⁰	
2.	Ц.долгор	Болортууд, Эдиймэлтэй хулзана	16 ⁰⁰ - 17 ³⁰	Анхны үйлдэл
3.	Алтантуул	Зр хорооны цэцэгч Дэлгүүр орж мэдээлэл илгүүлэх.	16 ⁰⁰ - 17 ³⁰	Мэдээлэл
4.	Эрдэнэчимэг			Нэгтгэх.
5.	Наран	Сургуулийн эко орчинтой танилцах	16 ⁰⁰ - 17 ³⁰	
6.	Баатар	Интернетеер аялзана	18 ⁰⁰ →	

Алтанзул баг явцын тайлан



Бадамлянхуа баг явцын тайлан



Үр дүн

- Хичээлийн эхэнд дэвшүүлсэн зорилго биелэн суралцагчид хэрэгцээтэй мэдлэгээ бүтээсэн.


Багшийн хувьд:

- Сэтгэл судлалын хүүхдийн насны онцлогийг судалж мэдсэн
- Арга зүйн хувьд насны онцлогт нь тохирсон тоглоом/ цаас, чулуу, даавуу/-г тоглох арга зүйг шинээр мэдсэн, алжаал тайлах дасгалын аргуудыг сурч сэдэлжүүлэлт болгон хэрэглэсэн.
- Цэцгийг арчлах, цэцэгний бэлэгдлийн талаар суралцагчдын тусламжтайгаар мэдэж авсан.
- Суралцагчдын явцын мэдлэг, чадвар, дутуу ойлгосон зүйлийг үнэлэх хүснэгтийн загвар гаргалаа.
- Төсөлт ажил хичээлийн бэлтгэл судалгааг багш нарт ойлгуулах хэрэглэгдэхүүн цогц материалтай болсон.

Дүгнэлт

- Төсөл ажил хичээлийн бэлтгэл судалгааг сайн хийвэл багш арга зүй, сэтгэл судлал, тухайн судалж буй зүйл, судалгааны арга зүй, менежмент, цахим бичвэрүүдийг хэрэглэх, технологийн боловсрол гэх мэт олон талаар өөрийгөө хөгжүүлэн ажлын байрандаа бие даан хөгжих түлхүүр нь болж байна.

Хавсралт 1



Хавсралт 2

1. *Белая* *анис* *мускат* *лимон*
хорошо *соединить* *с* *максимум*

[illegible]

Покажи мне сердце! и пусть
тоже выведет
всего меня сражен! пусть
даже сохнет мой язык
Счастья!

Кто-то эти пороги
старого
мне думает вдали.
Взвешиваю и пишу
моновидца
мне уже
Иногда мне снится
одежда.

С. В. Давыдов

То Москва
увар арга
укусанга


57x *ancine* *x masi-³*
zvi rosp *obzidan*
apra *zvi.*

C. Tangarai.

Тлоом ааме хитэ нэ
срэгдон сонирхолтой
байгаа сэтгэ сонгох
өөрсдөөр мэдлэг бүтэлтэй
түүнийг улаан бусад
түрэн дэлгэрмээр үйлдвэ

C. Tangereen

Хавсралт 3



МЭДСЭН ЗҮЙЛ

1. Т.А. хичээлийн хууль эрх зүйн үндэс.
— хичээл гэж юу вэ?
2. Т.А. ~~хичээлийн бэлтгэл судалгаа.~~
хичээлийн бэлтгэл судалгаа.
3. — Сэдэв сонголт. — Төлөвлөлт
— Сэдвийн тор үүсгэх. — Явцын тайлан
4. Т.А. хичээлийн явц.
Явцын тайланг сайжруулах.
Эцсийн тайлан.
Үнэлгээ.

МЭДСЭН ЗҮЙЛ

Хичээл гэж юу вэ?

- хичээлийн судалгаа.
- хичээлийн бэлтгэл, судалгаа

Төсөлт ажил гэж юу вэ? Эрх зүйн үндэс.

Т.А. хичээлийн тулгууройлолт.

• Сэдэв. — ^{сэдэв}сонголт. — сэдвийн задаргаа

• Төлөвлөлт.

• Судалгаа. — мэдээллийн боловсруулалт.

• Явцын тайлан

• Тайлангийн дараах судалгаа

• Эцсийн тайлан.

• Үнэлгээ